

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 9/А дугаартай тогтоолын 1 дүгээр хавсралт

**ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ  
ТОЙРГИЙН ШҮҮХЭД ЭРҮҮ, ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ, ДҮГНЭЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ,  
ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ САНАЛ, ХҮСЭЛТ  
ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ  
БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Тус шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, санал, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилоход Монгол Улсын шүүхийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад заасныг болон энэхүү журмыг баримтална.

1.2. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох ажиллагаа нь дараах зарчимд үндэслэсэн байна.

1.2.1. урьдчилан мэдэх боломжгүй,

1.2.2. тойрог дотор санамсаргүй тохиолдлоор,

1.2.3. ачаалал тэнцвэржүүлэх,

1.2.4. хуваарилагдсан шүүгч, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн нь зөвлөгөөний (танхимын) шийдвэргүйгээр өөрчлөгдөх боломжгүй,

1.2.5. хүний нөлөөллөөс ангид,

1.2.6. ил тод,

1.2.7. баримтжуулсан байх,

1.2.8. шуурхай байх,

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “хэрэг” гэж адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоолгон ирсэн хэрэг, прокуророос шилжин ирсэн эрүүгийн болон зөрчлийн хэрэг, прокуророос сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих санал гаргасан хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг, шүүгч, нийт шүүгчдээс татгалзаж ирсэн хэрэг, давж заалдах, хяналтын шатны шүүхэд хянуулахаар хүргүүлсэн хэрэг, дээд шатны шүүхээс шийдвэр нь хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүх өөрөө хянаж хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянаж, шийдвэр, тогтоолыг хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, нэгтгэж, тусгаарласан хэрэг, мөн шүүгчийн эрх нь дуусгавар болсон, эсхүл шүүгч удаан хугацаагаар эзгүй байгаа тохиолдолд бусад шүүгчид хуваарилах хэргийг ойлгоно.

1.3.2. “тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар” гэж тухайн тайлант оны шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаа ашиглан тогтоосон шүүгчдийн нэрсийн дараалал бүхий тойрог дотроос нэгдсэн системийг ашиглан санамсаргүй байдлаар сонгож хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахыг ойлгоно.

1.3.3. "хэрэг, гомдол, санал, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл" гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, сургалтад хамрагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй /ажиллаагүй/ байхыг ойлгоно.

1.4. Шүүхэд хүлээн авч байгаа хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ажлын цагт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу, прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг "Прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг хүлээн авах бүртгэл"-ийн дагуу шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийнэ.

1.5. Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудлыг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн системд, бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

1.6. Тус шүүхэд ирсэн эрүү болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна.

1.7. Шүүхэд ирсэн шүүн таслах ажиллагаатай холбоотой бичиг хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт, хугацаа сэргээлгэх хүсэлтийг харьяалах танхимын тэргүүний туслах хүлээн авч, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн системд, бүртгэлийн дэвтэрт бүртгэн Танхимын тэргүүн шүүгчид хуваарилна.

1.8. Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоогүй бичиг хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт, Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг Ерөнхий шүүгчийн туслах хүлээн авч, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн системд, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, Ерөнхий шүүгч шүүгчид хуваарилна.

#### Хоёр. Хэрэг хуваарилах арга сонгох талаар

2.1. Хэрэг, өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход хуульд заасан шаардлага хангасан программ хангамж ашиглана.

2.2. Нэгдсэн системд байрших тойрогт шүүгчдийн нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоож, нэгдсэн системд байршуулна.

2.3. Шүүхийн Тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

2.4. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид (CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт) хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн Тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

2.5. Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээр хуваарилагдсан хэрэг, өргөдөл, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

2.6. Шүүхэд ирсэн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд "тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим"-аар доорх 4 аргаар хуваарилна.

2.6.1. "Ердийн журмаар" 2.6.2, 2.6.3-д зааснаас бусад бүх хэргийг хуваарилна.

2.6.2. "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-аар 5-аас дээш хавтастай хэрэг, 5-аас дээш яллагдагчтай хэрэг, шүүгчийн хүлээж авсан хэргийг тойргоор хуваарилна.

2.6.3. "Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга" нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдсан эсхүл энэ тогтоол болон хавсралтаар зохицуулагдаагүй үндэслэлээр тухайн шүүгчид хуваарилж болохгүй, мөн 50-аас дээш хавтастай, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй хэргийг шийдвэрлэх шүүгчийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж, эсхүл санамсаргүй сонгох аргаар хуваарилна.

2.7. Хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан даргалагч шүүгч, шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, үндэслэл үүссэн, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилно. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэрэг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг дахин хуваарилахдаа тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилах сонголтыг нэгдсэн системд тохируулна.

2.8. Зөрчлийн хэрэг, эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан оролцогчдын гомдол, прокурорын дүгнэлтийг Эрүүгийн танхимын шүүгчдийн сугалсан сугалааны дарааллаар 1 удаа 20 хэргийг тойргоор, Ерөнхий шүүгчид 2 тойрог, Танхимын тэргүүнд 1 тойрог алгасаж, мөн дүүргүүдийг 3 тойрог болгон хуваарилна. *Тойргийг шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтооно.*

2.9. Шүүгчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ, мөн хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчээс

бусад Эрүүгийн танхимын шүүгчдийн сугалсан сугалааны дэс дарааллаар ажлын өдрийн ажлын цагт ирсэн 3 санал, хүсэлтийг тойргоор хуваарилна.

2.10. “Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах, яллагдагчид хязгаарлалт тогтоох, цагдан хорих” таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудлыг шийдвэрлэхийг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хүлээж авах бөгөөд уг асуудлыг ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдөр хүлээн авч, шийдвэрлэх ээлжээр ажиллах шүүгчийн дарааллыг тус тогтоолын шүүгчдийн зөвлөгөөний тогтоолд заасан дарааллаар хуваарилан шийдвэрлэнэ.

2.11. Ажлын өдрийн 16 цаг 30 минутаас хойш ирүүлсэн прокурорт буцаасан хэргийн тухайд цагдан хорих хугацааг сунгах санал, яллагдагчаар цагдан хорих санал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйл, 31.5 дугаар зүйл, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг жижүүрийн шүүгчид хуваарилан шийдвэрлүүлнэ.

2.12. Прокурорт буцаасан хэрэг шүүхэд буцаж ирсэн, эрүүгийн үндсэн хэргээс тусгаарласан хэргүүдийг өмнө хянан шийдвэрлэсэн шүүгчид дахин хуваарилна. Шүүгч ээлжийн амралттай байгаа тохиолдолд хэргийг бусад шүүгчид “Ердийн журмаар” хуваарилна.

2.13. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэргийг өмнө хянан шийдвэрлэсэн шүүгч болон шүүх бүрэлдэхүүнд дахин хуваарилна.

2.14. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг Танхимын тэргүүн шүүгчид хуваарилна.

2.15. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэгт холбогдуулан гаргасан гомдол, хүсэлт тухайн хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хуваарилна.

2.16. Шийтгэх тогтоолыг дээд шатны шүүхээс 2 /хоёр/ удаа, цагаатгах тогтоолыг 1 /нэг/ удаа хүчингүй болгосон бол тухайн шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хуваарилахгүйгээр алгасаж, өөр шүүгч, шүүх бүрэлдэхүүнд тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна.

2.17. Харьяалал тогтоож ирүүлсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчингүй болж ирсэн хэргийг “Ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах” аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна.

2.18. Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэрэг хуваарилах журамд зааснаар ямар хэргийг ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг, бусад хуваарилах аргаар хуваарилахаар хэрэг хуваарилах журамд заасны дагуу нэгдсэн системд мэдээллээ хийхэд систем өөрөө “тойрог дотор санамсаргүй сонгогдох

зарчим"-аар хуваарилсныг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүгчид хүлээлгэж өгнө.

### Гурав. Бусад

3.1. Шүүгч ажлын 5 /тав/ хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалттай, ээлжийн амралттай тохиолдолд эрүүгийн хэргийг, шүүгч өвчтэй, чөлөөтэй, сургалттай, ээлжийн амралттай тохиолдолд зөрчил хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлтийг хуваарилахгүй бөгөөд энэ тохиолдолд түүнд өмнө нь хуваарилсан хэрэг буцаж ирвэл бусад шүүгчид системээс "Тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим"-аар ердийн журмаар, ачаалал тэнцүүлж, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргуудын аль нэгээр хуваарилна. /Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2. Шүүгчийн өвчтэй, чөлөөтэй, сургалттай шалтгаан энэ тогтоолын 6.1-д заасан хугацаанд арилаагүй бол түүнд өмнө хуваарилагдсан хэрэг, санал, дүгнэлт, нэхэмжлэлийг системээс энэ журамд заасан аргуудын дагуу бусад шүүгч нарт хуваарилна.

3.3. Шүүгчид ээлжийн амралт, жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөө эхлэхээс өмнө ажлын 5 /тав/ хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоох, ажилд орох өдрөөс эхлэн хэрэг хуваарилна.

3.4. Шүүгч ээлжийн амралтаа эдлэхдээ өөрт хуваарилагдсан бүх хэргийг өөрөө шийдвэрлэнэ.

3.5. Шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч өвчтэй, чөлөөтэй, сургалттай, ээлжийн амралттай, шүүх хуралдаанд оролцож байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар тухайн шүүх хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Эрүү, Иргэний хэргийн системд байршуулсан нэрсийн дарааллаар шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнд оролцох өөр шүүгчийг томилж оролцуулж болно.

3.6. Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн алдаанаас үүдэлтэйгээр шүүгч нарын хэргийн ачааллыг тэнцүүлэх шаардлага гарвал шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

3.7. Шүүгч шинээр томилогдон ирсэн тохиолдолд нэрийг шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын 1.1.1-д нэмж, мөн хавсралт журмын 4.1, 4.2-д заасан хүндэтгэн үзэх шалтгаантай, шүүгчдийн ээлжийн амралтын харилцан адилгүй хугацаанаас шалтгаалан шүүгчдийн хэргийн ачаалал алдагдаж, түүнийг тэнцвэржүүлэх шаардлага гарсан зэрэг тохиолдолд зарим шүүгчдийн хэрэг хуваарилалтыг тодорхой хугацаанд зогсоож болно.

3.8. Хэрэг, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шүүгчид хуваарилахтай холбоотой энэ журамд заагаагүй асуудлыг тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэх ба энэ тохиолдолд сугалаагаар тогтсон тойргийн журмыг баримтална.

# ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ

Төрийн захиргааны тусгай газрын газар зүйн үйлчилгээний газрын дарга Т.ОМОНХУУ